

## МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 03.080.30

Худалдааны үйлчилгээ. Худалдааны газар түүний ангилал, нэр томьёо	MNS 6506: 2023
Services of trade. Classification of trade enterprises	MNS 6506:2015-ын оронд

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 20..... оны ....сарын .... -ны өдрийн .... дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 20.... оны .... дугаар сарын .. -ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

### 1 Хамрах хүрээ

Энэхүү стандартад заасан ангилал, нэр томьёо нь дотоод худалдааг системчлэн тодорхойлсон. Тус стандартаар тодорхойлсон ангилал, нэр томьёог стандартчиллын ажлын хүрээнд хамаарах бүх төрлийн баримт бичигт ашиглахыг зөвлөмж болгосон болно.

### 2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах стандарт, баримт бичгээс иш татсан бөгөөд эдгээрт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас иш татна. Үүнд:

MNS 5021-2:2023, *Жижиглэн худалдааны газар түүний үйлчилгээ, Ерөнхий шаардлага*

MNS 5364:2011, *Худалдааны агуулах. Ерөнхий шаардлага*

UCS 1201B:2022, *Худалдаа үйлчилгээний газрын гадна орчны ерөнхий шаардлага*

UCS 1202B:2022, *Худалдаа үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавих ерөнхий шаардлага*

### 3 Нэр томьёо, тодорхойлолт

#### 3.1

##### **худалдаа /худалдааны үйл ажиллагаа/**

бүх төрлийн түүхий эд, бэлдэц, бараа бүтээгдэхүүнийг худалдан авах, борлуулахтай холбоотой бизнесийн үйл ажиллагааны төрөл

#### 3.2

##### **бөөний худалдаа**

бүх төрлийн түүхий эд, бэлдэц, бараа бүтээгдэхүүнийг зах зээлд бөөнөөр худалдан борлуулах, худалдан авахтай холбоотой бизнесийн үйл ажиллагааны төрөл

#### 3.3

##### **жижиглэн худалдаа**

бүх төрлийн түүхий эд, бэлдэц, бараа бүтээгдэхүүнийг зах зээлд эцсийн хэрэглэгчид шууд худалдан борлуулах бизнесийн үйл ажиллагаагы төрөл

#### 3.4

##### **дистрибьютерийн худалдаа**

нийлүүлэгчтэй хийсэн гэрээнд заасны дагуу барааг ашиг олох зорилгоор өөрийн нэрийн өмнөөс худалдан борлуулах эрх бүхий хуулийн этгээдийн хийх худалдаа

### **3.5**

#### **худалдааны байгууллага**

барааг худалдах, худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах эрх бүхий хуулийн этгээд

### **3.6**

#### **худалдааны газар**

стандартад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй, мэргэжлийн хүний нөөцөөр хангагдсан, худалдан авагчдын үйлчлүүлэх тав тухтай орчинг бүрдүүлсэн худалдааны газар түүний салбар

ТАЙЛБАР: Худалдааны байгууламж нь суурин, суурин бус байж болно.

### **3.7**

#### **суурин байгууламж**

газарт цутгагдаж суурилагдсан инженерийн шугам сүлжээнд холбогдсон байгууламж

### **3.8**

#### **суурин бус байгууламж**

инженерийн шугам сүлжээ, түүний дотор хөдөлгөөнт байгууламжтай холбогдсон (технологийн холболт) эсэхээс үл хамааран газарт цутгаж холбоогүй зөөвөрлөх боломжтой байгууламж

### **3.9**

#### **худалдааны сүлжээ**

нэгдсэн нэг удирдлага, стандарттай худалдааны газрын хэлхээ

### **3.10**

#### **бараа**

эдийн засгийн болон нийгмийн ач холбогдол бүхий хүний хэрэгцээг хангах худалдаж, солилцож болох эд зүйлс

### **3.11**

#### **барааны нэр төрөл**

хэрэглээний зориулалт, шинж чанараараа нэг бүлэгт багтдаг бараанд оноосон нэр

### **3.12**

#### **өргөн хэрэглээний бараа**

хэрэглэгчийн хэрэгцээг хангах өргөн нэр төрлийн хүнс болон хүнсний бус бүх бүлгийн бараа

### **3.13**

#### **өдөр тутмын эрэлттэй бараа**

хэрэглэгчийн байнгын эрэлт, хэрэгцээт хүнсний болон ахуйн хэрэглээний бараа

### **3.14**

#### **хүнсний түргэн муудах, эмзэг бүтээгдэхүүн**

физик, химийн шинж чанар нь хурдан өөрчлөгдөх, хадгалалтын онцгой горим шаарддаг хүнсний бүтээгдэхүүн

### **3.15**

#### **үнэ**

барааны нэр төрөл, тоо хэмжээ, чанарт тохирсон мөнгөн төлбөрийн хэмжээ

### **3.16**

#### **үнийн шошго**

худалдан авагчид бараа, бүтээгдэхүүний үнийг санал болгох бичиглэл бүхий цаасан болон электрон үнийн хаяг

ТАЙЛБАР: ПОС системд алдаа гарахад үнийн шошго дээр заасан үнийг баримтлана.

### **3.17**

#### **татварын нэгдсэн систем**

бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний төлбөрийн баримтын мэдээллийг цуглуулах, боловсруулах, тайлагнах үйлдэлтэй нэгдсэн систем

### **3.18**

#### **бүртгэлийн машин**

албан татвар суутган төлөгчийн борлуулалтыг төлбөрийн баримтад заасаны дагуу бүртгэж, бүртгэлийн мэдээллийг төлбөр тооцооны системд дамжуулах тусгай зориулалт бүхий кассын машин, түүний салшгүй хэсэг болсон ПОС терминал буюу түүнтэй адилтгах програм хангамж бүхий тоног төхөөрөмж

ТАЙЛБАР: ПОС /Point Of Sales/ систем нь ажлын байрыг бүрэн автоматжуулах зориулалттай техник, програм хангамжийн багц

### **3.19**

#### **төлбөрийн баримт**

тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийн таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримт

### **3.20**

#### **худалдан авагч**

бараа, үйлчилгээг худалдан авах, захиалах хүсэлтэй хувь хүн, хуулийн этгээд

### **3.21**

#### **худалдааны технологи**

барааг дэлгүүрт хүлээн авах, байршуулах, хадгалах, худалдаалах стандартын шаардлага хангасан цогц ажилбар

### **3.22**

#### **худалдан авагчдад үйлчлэх технологи**

худалдан авагчийг үйлчилгээнд угтах, барааг худалдан борлуулах, төлбөр тооцоо хийх, үдэх үйлчилгээний цогц ажилбар

### **3.23**

#### **планограмм**

барааг бүлэглэн ангилж төрөлжүүлэн өрөлт байршлын зохистой харьцааг боловсруулах загвар

### **3.24**

#### **категори бодлого**

ижил төстэй эсвэл ялгаатай шинж чанартай бүлэг, дэд бүлгийн барааны нэр төрлийг бүрдүүлэх, шинэчлэх, гүнзгийрүүлэх, өргөжүүлэх, байршуулах бодлого

### **3.25**

#### **борлуулагч**

барааг сурталчлан таниулах, мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, худалдах үүрэгтэй бөөний худалдааны газрын ажилтан

### **3.26**

#### **худалдагч**

байгууллага, эрх зүйн хэлбэрээс үл хамааран хувиараа бизнес эрхлэгч эсвэл хууль тогтоомжид заасан тохиолдолд худалдах, худалдан авах гэрээ, бусад ижил төстэй гэрээний дагуу бараа борлуулж, үйлчилгээ үзүүлж буй иргэн (хувь хүн)

### **3.27**

#### **худалдааны зөвлөх**

жижиглэн худалдааны газрын мэргэшсэн ажилтан

### **3.28**

#### **бараа ачигч, буулгагч**

барааг тээврийн хэрэгслээс механик болон автомат төхөөрөмжөөр буулгах, ачих, агуулахад шилжүүлэх, зөөвөрлөхтэй холбоотой иж бүрэн ажилбарыг гүйцэтгэх үүрэгтэй худалдааны газрын туслах ажилтан

### **3.30**

#### **зориулалтын тээврийн хэрэгсэл**

барааны шинж чанар, чанар байдлыг алдагдуулахгүй, гэмтэж муудахаас хамгаалах зориулалтын хөргөөх, хөлдөөх, чийглэх зэрэг нэмэлт төхөөрөмжөөр тоногдсон битүү тэвш бүхий тээврийн хэрэгсэл

### **3.31**

#### **худалдааны газрын нэмэлт үйлчилгээ**

Худалдаа үйлчилгээний чанар, соёлыг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор өөртөө үйлчлэх, шуудан, харилцаа холбоо, илгээмж, хүргэлтийн үйлчилгээ, төлбөр тооцооны болон ахуйн гэх мэт олон төрлийн үйлчилгээ

### **3.32**

#### **түргэн хоол үйлчилгээний хэсэг**

шууд хэрэглэх хүнсний бүтээгдэхүүнийг халаах, халууныг тогтмол температурт барих, хадгалах, үйлчлэх ердийн болон автомат тоног төхөөрөмж, ширээ сандал, зогсоо байдлаар үйлчлүүлэх тавиур, утасгүй интернет /Wi/ орчин бүхий үйлчилгээний хэсэг

### **3.33**

#### **борлуулалтын дараах үйлчилгээ**

техникийн болон хэрэглээ, арчилгаа, тордолтын онцгой горим шаарддаг бараа, бүтээгдэхүүний талаар худалдан авагчдад нэмэлт зөвлөгөө өгөх, засвар үйлчилгээ үзүүлэх үйлчилгээ

### **3.34**

#### **худалдааны газрын хүчин чадал**

худалдааны болон худалдааны бус талбайн нийлбэр

### **3.35**

#### **худалдааны талбай**

худалдагчийн ажлын байр, худалдан авагчийн зорчих хэсэг, лангуу тавиур, тооцооны болон бусад тоног төхөөрөмжийг байршуулсан талбайн нийлбэр

### **3.36**

#### **худалдааны бус талбай**

барааг хүлээн авах, худалдаанд бэлтгэх, хадгалах байрны болон захиргаа аж ахуй, ариун цэврийн өрөөний талбайн нийлбэр

### **3.37**

#### **бөөний худалдааны төв**

бизнесийн хэрэгцээнд зориулан барааг өөртөө үйлчлэх хэлбэрээр худалдах бөөний худалдааны газар

### **3.38**

#### **зах**

худалдаа эрхлэгчдийг төвлөрүүлсэн, зохион байгуулалттайгаар худалдаа эрхлэх байнгын болон байнгын бус үйл ажиллагаатай бүс

ТАЙЛБАР: Байгууламж нь битүү, хагас битүү, задгай байж болно.

### **3.39**

#### **худалдааны төв**

нэг байгууламжид төвлөрсөн, нэгдсэн удирдлагатай олон хэв маяг бүхий дэлгүүр, үйлчилгээний газруудын нэгдсэн цогцолбор

### **3.40**

#### **агуулах дэлгүүр**

бизнесийн болон гэр бүлийн хэрэглээнд зориулан барааг бөөнөөр болон жижиглэнгээр өөртөө үйлчлэх аргаар худалдах худалдааны газар

### **3.41**

#### **жижиглэн худалдааны газар**

бараа, бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн хувийн болон гэр бүл, ахуйн хэрэглээнд зориулан худалдан борлуулах үйлчилгээ бүхий худалдааны газар

### **3.42**

#### **худалдааны газрын төрөл /хэв маяг/**

худалдааны газрын хүчин чадал, байршил, бараа, бүтээгдэхүүнийг худалдаалах, худалдан авагчдад үйлчлэх арга технологиос хамаарч ялгагдах онцлог

#### **3.42.1**

##### **молл**

томоохон хүчин чадалтай худалдаа үйлчилгээний болон зугаа цэнгэлийн төв

### **3.42.2**

#### **их дэлгүүр**

өргөн нэр төрлийн барааг төрөлжсөн тасгуудаар бүрэн үйлчилгээ үзүүлж худалдах том болон томоохон хүчин чадалтай жижиглэн худалдааны газар

### **3.42.3**

#### **хайпермаркет**

хүнсний болон хүнсний бус өргөн нэр төрлийн барааг өөртөө үйлчлэх аргаар худалдах том болон томоохон хүчин чадалтай жижиглэн худалдааны газар

ТАЙЛБАР: Өөрийн нэрийн хоол, нарийн боовны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний үйлчилгээг болон төрөл бүрийн нэмэлт үйлчилгээг зохион байгуулах

### **3.42.4**

#### **супермаркет**

хүнсний болон ахуйн хэрэглээний барааг төрөлжсөн тасгуудаар өөртөө үйлчлэх аргаар худалдах, дунд түүнээс дээш хүчин чадалтай дэлгүүр

### **3.42.5**

#### **хүнсний дэлгүүр**

хүнсний бүлгийн бараа, бүтээгдэхүүнийг уламжлалт хэлбэрээр худалдаалах багавтар хүчин чадалтай дэлгүүр

### **3.42.6**

#### **минимаркет**

өдөр тутмын эрэлттэй хүнсний болон хүнсний бус ариун цэвэр, эрүүл ахуйн жижиг бараа, бүтээгдэхүүнийг өөртөө үйлчлэх аргаар худалдах, багавтар хүчин чадалтай дэлгүүр

### **3.42.7**

#### **ая тухтай дэлгүүр**

өдөр тутмын эрэлттэй хүнсний болон хүнсний бус бараа бүтээгдэхүүнийг худалдах, түргэн хоол үйлчилгээний хэсэгт зогсоогоор болон сууж үйлчлүүлэх тавиур, тавцан, ширээ, сандал байршуулж хэрэглэгч өөрөө өөртөө үйлчилэх газар

### **3.42.8**

#### **цахим дэлгүүр**

худалдан авагчид бараа бүтээгдэхүүний нэр төрөл, үнэ, төлбөрийн нөхцөл, худалдан авалтын талаарх шаардлагатай мэдээллийг цахимаар илгээж худалдан авагчаас барааг худалдан авах шийдвэрийг хүлээн авч баталгаажуулсан тохиолдолд заасан хаягаар барааг хүргэж үйлчлэх

### **3.42.9**

#### **хоршооллын дэлгүүр**

хоршоологчдын боловсруулж, үйлдвэрлэсэн барааг худалдах, дундаас доош хүчин чадалтай худалдааны газар

### **3.42.10**

#### **аутлет(outlet)**

хийц загвар нь хуучирсан, үлдэгдэл нөөц ихтэй барааг зах зээлийн дунджаас доогуур үнээр худалдах, багавтар түүнээс дээш хүчин чадалтай худалдааны газар

### **3.42.11**

#### **бутик**

чамин загварын хязгаарлагдмал эрэлттэй барааг тансаг, тухтай орчинд худалдан борлуулах дундаас доош хүчин чадалтай газар

### **3.42.12**

#### **үйлдвэрийн нэрийн барааны дэлгүүр**

үйлдвэрлэгч өөрийн нэрийн барааг худалдах дундаас доош хүчин чадалтай газар

### **3.42.13**

#### **үзүүлэнгийн танхим (show room)**

барааны загвар дээжийг үзүүлэн сурталчилж сонгуулах, загвараар худалдах дундаас дээш хүчин чадалтай газар

### **3.42.14**

#### **хуучин барааны (секонд хенд) дэлгүүр**

хэрэглээнд байсан барааг тодорхой үнийн хоргодолтойгоор худалдах дундаас доош хүчин чадалтай газар

### **3.42.15**

#### **татваргүй барааны дэлгүүр**

барааг гаалийн хяналт дор татваргүй худалдах дундаас доош хүчин чадалтай газар

### **3.42.16**

#### **мухлаг**

тодорхой /хязгаарлагдмал/ нэр төрлийн хүнсний болон ахуйн жижиг барааг худалдах бага хүчин чадалтай худалдааны газар

### **3.43**

#### **дэлгүүрийн бус худалдааны төрөл**

барааг дэлгүүрийн худалдааны талбай ашиглахгүйгээр явуулын болон суурин бус байгууламжид холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн жижиглэнгээр худалдах

#### **3.43.1**

##### **авто чингэлэгийн худалдаа**

тоноглогдсон авточингэлэгт богино хугацаанд борлуулах барааны нөөц бүрдүүлж худалдах

#### **3.43.2**

##### **худалдааны автоматаар хийх худалдаа**

зориулалтын автомат төхөөрөмжийн тусламжтайгаар худалдагчийн оролцоогүйгээр бараа худалдах

#### **3.43.3**

##### **утас, шуудангаар хийх худалдаа**

харилцаа холбооны хэрэгсэл ашиглан бараа худалдах

#### **3.43.4**

##### **цахим худалдаа**

интернэт сайтаар дамжуулан бараа худалдах

### **3.43.5**

#### **шууд худалдаа**

барааг албан ёсны бие даасан гэрээт борлуулагч биечлэн хүргэж худалдах

### **3.43.6**

#### **явуулын /үүргийн/ худалдаа**

барааг хэрэглэгчид ойртуулан, зөвшөөрөгдсөн байршилд түр хугацаагаар үйлчилгээ үзүүлж худалдах

## **4 Жижиглэн худалдааны газрын ангилал**

### **4.1 Худалдааны газрыг үйл ажиллагаагаар нь:**

- дэлгүүрийн худалдаа
- дэлгүүрийн бус худалдаа

### **4.2 Бараа худалдах хэлбэрээр нь:**

- Уламжлалт /лангуугаар худалдах/
- Өөртөө үйлчлэх
- Загвараар
- Каталогтар
- Цахимаар /“цахим худалдаа” цахим мэдээллийн сүлжээг ашиглан хийгдэх худалдааг/
- Хүргэлтээр
- Шууд худалдаа /үйлдвэрлэгчээс хэрэглэгчид шууд хүрч байгаа бараа, үйлчилгээ болон албан ёсны төлөөлөгч этгээдээр дамжуулан хүргэх худалдаа, үйлчилгээг/;

### **4.3 Төрөлжилтөөр нь:**

- Нийлмэл
- Төрөлжсөн
- Нарийн төрөлжсөн
- Холимог

ТАЙЛБАР: Нийлмэл хүнсний, хүнсний бус барааны бүлгээр, төрөлжсөн тодорхой бүлгийн барааны нэр төрлөөр, нарийн төрөлжсөн тодорхой дэд бүлгийн бараагаар, холимог нь төрөл бүрийн барааны бүлгээр нэр төрлийг бүрдүүлэх

**ТӨГСӨВ.**

**Ном зүй**

ГОСТ Р 51773-2009, Услуги торговли. Классификация предприятий торговли  
ГОСТ Р 51303-2013, Торговля. Термины и определения